



**НИЙСЛЭЛИЙН  
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЛБАНЫ  
ДАРГЫН АЛБАН ДААЛГАВАР**

2015 оны 01 сарын 14 өдөр

Дугаар 15/16

Улаанбаатар хот

Албаны нийт бие бүрэлдэхүүнд

Хууль зүйн сайдын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/248 тоот тушаал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас 2015 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 4/100 тоот албан бичгээр ирүүлсэн үүргийн хэрэгжилтийг хангах зорилгоор ДААЛГАХ НЬ:

1. Хууль зүйн сайдын 2014 оны “Архидан согтуурахтай тэмцэх талаар авах зарим арга хэмжээний тухай” А/248 тоот тушаалыг нийт бие бүрэлдэхүүн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллахыг үүрэг болгосугай.

2. Тушаалтай холбогдуулан төлөвлөгөө гарган ажиллахыг мэргэжилтэн, /хошууч Э.Дүүрэнцэнгэл/-д үүрэг болгосугай.

3. Тушаалыг зөрчсөн албан хаагчид хариуцлага тооцохыг хүний нөөц, сургалт, мэдээлэл хариуцсан ахлах мэргэжилтэн, /дэслэгч П.Сумъяа/-д үүрэг болгосугай.

4. Тушаалын биелэлт, үр дүнг улирал бүр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хяналт шалгалт, аюулгүй байдлын хэлтэст хүргүүлэхийг мэргэжилтэн /дэслэгч П.Сумъяа/-д үүрэг болгосугай.

ДАРГА, ХУРАНДАА

Э.БАТБАЯР